



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/503

Чингис хот

Гамшгаас хамгаалах Команд штабын
сургууль зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.13, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.5, 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.1, 32.1.2 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сум орон нутгийн гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах Команд штабын сургуулийг тус аймгийн Жаргалтхаан суманд 2020 оны 11 дүгээр сарын 09-12-ны өдөр, Дэлгэрхаан сумдад 2020 оны 11 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2. Тус сургуульд шаардагдах 2.876.490 /коёр сая найман зуун далан зургаан мянга дөрвөн зуун ер/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Команд штабын сургууль зохион байгуулах комиссыг хавсралтаар баталсугай.

4. Дээрх арга хэмжээг тусгай удирдамж төлөвлөгөөний дагуу сахилга хариуцлага, чанарын өндөр түвшинд зохион байгуулж, дүнг танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ИДЭРБАТ

231010878

10 Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 30 өдрийн 1/503
дугаар захирамжийн хавсралт

КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



Комиссын дарга	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	П.Элбэгсайхан	Онцгой байдлын газрын орлогч урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Дэд хурандаа
Гишүүд	Х.Наранхүү	Зооноз өвчин судлалын төвийн дарга
	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
	Д.Амаржаргал	Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн ахмад